



НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/116

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг
дүүрэгт хэрэгжүүлэх 2019 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тухай бүр танилцуулж, холбогдох газруудад биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Б.Энхболд/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

1170201142



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны
сарын 09-ны өдрийн захирамжийн хавсралт

АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Хэрэгжүүлэх байгууллага	
							Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч байгууллага
1	2	3	4	5	6	7	8	9
Наг. Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, нийтийн албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалтыг мерит зарчимд тулгуурлан зохион байгуулах, ёс зүй, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр								
4.1.1.1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг холбогдох байгууллагаар хянуулсны дараа албан тушаалд томилох	Жилдээ	Төрийн жинхэнэ албан тушаалд томилох үйл ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагдана.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
4.1.1.2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, үр чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн	2	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, үр чадварын шаардлагыг үндэслэн төрийн албанд томилж, дээшлүүлэх	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур, үр чадварыг үндэслэн, төрийн албанд томилох, дээшлүүлэх тогтолцоо бүрдсэн	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд

	7	Ажлын байрын зохистой орчин (ёс зүйн зөрчилгүй албан хаагч, байгууллага)-ыг бий болгох	4 дүгээр улиралд	Ёс зүйн зөрчилгүй албан хаагч, байгууллагыг шалгаруулсан байна.		2,0	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
	8	"Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн гэрээ"-ний үлгэрчилсэн загварыг боловсруулж батлуулах	4 дүгээр улиралд	Төрийн албан хаагч нэг бүртэй ёс зүйн гэрээ байгуулж, хэрэгжилтийг тооцсон байна.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
	9	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад нийтээр дагаж мөрдөх ёс зүйн нийтлэг журмыг батлуулж хэрэгжүүлэх	4 дүгээр улиралд	Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	-	-	-	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
4.1.1.9.Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	10	Архивын баримтыг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлж, мэдээллийн нэгдсэн сангийн лавлагаа мэдээллийн эрэлт, хайлтыг сайжруулах	Жилдээ	Архивын лавлагаа мэдээлэл авах боломж, нөхцөл нэмэгдэнэ.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
4.1.1.10.Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	11	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх	1 дүгээр улиралд	Модуль, хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж явуулсан байна.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр								
4.1.2.1.Төрийн үйлчилгээг иргэдэд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний	12	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудад хандсан иргэдийн өргөдөл, гомдлыг	Жилдээ	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа богино болж, шийдвэрлэлтийн	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд

		байгууллагуудын утасны дугаар, хаяг байршлын мэдээлэл, өргөдөл гомдлыг, санал хүсэлтийг /текст, фото, видео хэлбэрээр/ авах						
4.1.2.7.Төрийн үйлчилгээний чанар, хуртэмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	18	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2018 оны шинэчлэсэн мэдүүлгийг бүртгэх, тайланг нэгтгэх	1 дүгээр улиралд	Мэдүүлгийг бүртгэн, тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн байна.	-	-	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
	19	Төрийн зарим үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээ хийж, иргэдийн үнэлгээний картын систем, үйлчилгээний соёл стандартыг шинэчлэх	Жилдээ	Төрийн үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн байна.	-	-	-	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр								
4.1.3.1.Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	20	Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг батлагдсан аргачлал, итгэлцүүрийн дагуу тооцон хуваарилж, иргэдийн санал оролцоомд тулгуурлан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийж, төсвийн зарцуулалтыг иргэдэд нээлттэй, ил тод болгох	Жилдээ	Иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын ажлуудыг хийсэн байна.	-	-	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газар

	21	Гадаадын зээл тусламж, орон нутгийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх.	Жилдээ	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нээлттэй болж, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна.	-	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	
	22	Дүүргийн нутгийн захирааны байгууллагуудад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийх, зөрчлийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэх.	Жилдээ	Эрсдлийн удирдлага, хяналтын тогтолцоо бий болсон байна.	-	-		Дүүргийн Дотоод аудитын алба
4.1.3.4.Төсвийн төслийг хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	23	Дүүргийн 2020 оны төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусгаж, ДИТХ-аар хэлэлцүүлж батлуулах	4 дүгээр улиралд	Төсвийн төслийг иргэдийн оролцоотойгоор хэлэлцэж баталсан байна.	-	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	
Дөрөв, Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих, төрийн албан хаагчийг соён гэгээрүүлэх чиглэлээр								
4.1.5.5.Цахим сүлжээг ашиглах, байнгын ажиллагаатай утас ажиллуулах замаар авилга, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг авах, мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх	24	Авилга, албан тушаалын гэмт хэрэг, ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл авах 7777-1965 байнгын утсыг ажиллуулж хэвшүүлэх	Жилдээ	Авилга, ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээлэл авах арга хэлбэр сайжирсан байна.	-	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газар	
4.1.10.1.Авлигын нийгмийн аюулыг ухуулан таниулах	25	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах зорилгоор	Жилдээ	Төрийн албан хаагчдад шударга ёсны үзэл санаа	-	3,0	-	Дүүргийн Засаг даргын Тамгын газар

авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд, иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог үе шаттай хэрэгжүүлэх		төрийн албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах		төлөвшсөн байна.				
Тав. Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилт, ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр								
Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, цахим хуудсыг шинэчлэх, өргөжүүлэх	26	Байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг нээлттэй байлгах, цахим хуудсыг шинэчлэн өргөжүүлэлт, шинэчлэлтийг хийх	Жилдээ	Иргэдийн үнэн зөв, бодит мэдээлэл авах боломж нөхцөл нэмэгдсэн байна.	-	-	-	Дүүргийн нутгийн захиргааны байгууллагууд